



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 19 өдөр

Дугаар А/549

Чингис хот

“Мотоцикл, мопедийн хөдөлгөөнийг түр
хугацаагаар хориглох тухай”

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Зорчих хэсгийн гадаргуу цасаар хучигдсан халтиргаа гулгаа үүсч тээврийн хэрэгслийн зорчих хэсгийн нөхцөл байдал хүндэрсэн үед мотоциклоор замын хөдөлгөөнд оролцогчдын эрүүл мэнд, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, учирч болох хор хохирол эрсдэлийг багасгах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах зорилгоор аймгийн нутаг дэвсгэрт мотоциклтой замын хөдөлгөөнд оролцохыг 2021 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл түр хугацаагаар хязгаарласугай.

2. Хэрэгжилтэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах, ард иргэдэд хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай анхааруулга сэрэмжлүүлэг өгч сурталчлах ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай хүргэж, зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Д.Батхүү), сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3. Захирамжид тусгагдсан арга хэмжээний үр дүн, явц байдлыг Цагдаагийн газрын дарга, сумдын Засаг дарга нарт танилцуулж, хойшид авах арга хэмжээний саналыг оруулж байхыг сумдын Засаг дарга, Цагдаагийн газрын дарга, (цагдаагийн хурандаа Д.Батхүү), Замын цагдаагийн тасгийн дарга, (цагдаагийн ахмад С.Пүрэвээ) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231010511